

ТОРГОХ ЯЛЫН ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

CONCEPT AND CHARACTERISTICS OF CRIMINAL PUNISHMENT

Э.Батбаяр

Дотоод хэргийн их сургуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа;

Торгох ял түүний ойлголт, онцлогийн талаар авч үзэх нь торгох ялын тухай үндсэн мэдлэг олгох, торгох ялын мөн чанар, агуулга, зорилго зэрэг эрүүгийн эрх зүй дэх ялын сургаалтай бүрэн танилцах эхлэл болох юм.

Хэл зүйн хувьд авч үзвэл “торгууль” гэх үгийн эхний утга нь “ял болгож авах мөнгө, торгуулийн мөнгө, тавин төгрөгийн торгууль ногдов” гэсэн утгатай,¹ хууль зүйн толь бичигт англи хэлнээ торгууль гэдгийг “fine” гэж тэмдэглэсэн байна².

Эртний ял шийтгэлийн цусан өшөө авах үзэл сэтгэлгээнд суурилж бий болсон талионы зарчим нь аажимдаа композицийн систем рүү шилжиж, хатуу харгис ялын оронд нөхөн төлөөс төлөх, хохирол төлбөрийг гаргуулах, үүнд торгууль оногдуулах явдал багтаж байсан зэргээс үзэхэд ийм ойлголтоос торгох ялын гарал зүй эхлэл авсан байх үндэслэлтэй.

Жишээ нь: “**золио авах**” гэж Манжийн үеийн цааз бичигт хэрэглэж байсан ялтай холбоотой ойлголт бөгөөд алах ялыг өөр хөнгөн ялаар /торгууль, пүнлүү хасах гэх мэт/ солих, алах ялыг малаар сольж амь хэлтрүүлэхийг хэлдэг байжээ³.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн **5.3** дугаар зүйлд зааснаар, **Торгох ялын** эрх зүйн зохицуулалт нь дор дурдсанаар хуульчлан тогтоогджээ. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгж /цаашид "нэгж" гэх/-тэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг **торгох ял** гэнэ.

2. Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

3. Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966., 544 дэх тал.

² С.Нарангэрэл. МУ-ын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ., 2021., 396 дахь тал.

³ Б.Баярсайхан. Хууль зүйн тайлбар толь. УБ., 2003., 256 дахь тал.

4. Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.

5. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

6. Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг торгох ялаар солихгүй.

Эрүүгийн хуульд зааснаар авч үзвэл, дан ганц торгох ялтай гэмт хэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангид байхгүй байна /өмнөх 2002 оны Эрүүгийн хуульд байсан юм, жишээ нь: жагсаал цуглаан хийх эрх чөлөөг зөрчих /үз. 132 дугаар зүйл/.

Гагцхүү торгох ялыг хорих ба, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг ялуудтай хамт буюу сонгох санкцын хэлбэрээр тогтоожээ. **Жишээ нь:** Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан бол 450-1350 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл ... нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зорчих эрхийг хязгаарлах /үз. 11.6/ ял шийтгэнэ.

Торгох ялын хэмжээг хуульчилж ирсэн байдал:

№	Хууль	Ялын нэр	Хэмжээ	Итгэлцүүр
1	1926 оны Шүүх цаазын бичиг /11 дүгээр зүйл/	Мөнгөн ял торгох	10 төгрөг /доод/	Төгрөг ба Мөнгө
2	1929 оны Шүүх цаазын бичиг /11 дүгээр зүйл/	Мөнгө торгох	100 төгрөг /дээд/	Төгрөг
3	1934 оны Шүүх цаазын бичиг /28 дугаар зүйл/	Мөнгөөр торгох	2 сарын хөлс /дээд/	Мөнгө
4	1942 оны Эрүүгийн хууль /41 дүгээр зүйл/	Мөнгөн торгууль	2 сарын цалин /дээд/	Мөнгө
5	1961 оны Эрүүгийн хууль /23 дугаар зүйл/	Торгох	доод хэмжээг заагаагүй	Мөнгө
Тайлбар: Тус хуульд анх “торгох” гэсэн нэрийг хэрэглэжээ. Мөн нэмэгдэл ялаар хэрэглэж болохыг заасан байна. /үз. 17 дугаар зүйл. 1966.11.02/.				
6	1986 оны Эрүүгийн хууль /29 дүгээр зүйл/	Торгох /үндсэн, нэмэгдэл/	250-1500, 5000 төгрөг	2.000-250.000, 500.000, үндсэн ял /1993 онд/
7	2002 оны Эрүүгийн хууль /47 дугаар зүйл/	Торгох /үндсэн ял/	5-500 дахин	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

8	2015 оны Эрүүгийн хууль /5.3 дугаар зүйл/	Торгох ял /үндсэн/	100-40.000 нэгжтэй тэнцүү	Нэгж, 1 нэгж 2000 төгрөг
9	Нэмэлт, өөрчлөлт	Торгох ял	451-40.000	1 нэгж 1000 төгрөг

Торгох нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгалаа олсон ялын төрлүүдийн нэг бөгөөд эрүүгийн эрх зүй дэх ялын тогтолцоонд зонхилох байр суурийг эзэлдэг ял юм.

Орчин цагт ял нь “Хорих болон хорихоос өөр төрлийн ял” гэж зааглагдаж буй хандлага түгээмэл болсон учир торгох ялыг хорихоос өөр төрлийн буюу нийгмээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгаарлахгүй шинжтэй ялын тогтолцооны хүрээнд, “альтернатив” шинжийг нь харгалзаж, ялын бодлогын хувьд “хүний эрх, энэрэнгүй ёсны зарчимд тулгуурласан, хорих ялаас хөнгөн шинж чанартай” байдалд нь үндэслэж, сонгох санкц болж буй нөхцөлд өргөн хэрэглэх болсон байна.

Ингэснээрээ гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, хугацаа тогтоож хорихгүйгээр торгууль ногдуулах замаар уг этгээдийн өмчлөх эрхэд тодорхой хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгжиж, торгох ялыг эс биелүүлэх буюу зайлсхийсэн тохиолдолд хорих ялаар солих хууль зүйн үр дагавар үүсэхийг нь заавал анхааруулж шийтгэх тогтоолд шүүгч дурдах юм.

Торгох ял нь уг ялаар шийтгүүлж байгаа хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгтэй хууль зүйн хувьд шалтгаан ба үр дагаврын холбоог үүсгэж, улмаар энэ ялыг оногдуулах нь зохимжтой агаад эрүүгийн хариуцлагын нийтлэг “цэрлүүлэх, нийгэмшүүлэх, эрх сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зэрэг /ялын/ зорилгыг хангахад чиглэсэн, эрүүгийн эрх зүйн “шударга, энэрэнгүй, тэгш, хууль ёсны, ял гарцаагүй байх” зарчмуудад үндэслэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд, шүүхээс, торгуулийн тогтоосон нэгжийн хэмжээгээр, мөнгөн төгрөг төлөх хэлбэрээр торгууль оногдуулахыг **торгох** ял гэнэ.¹

- зөвхөн гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай хувь хүн болон хуулийн этгээдэд ял болгож оногдуулна;

¹ Торгох ялын үндэс нь торгууль юм. Энэ торгууль нь /бусад торгуулийг бодвол/ эрүүгийн хуульд заагдсан ял болохын хувьдаа Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр тооцогдож байгаа болно. Иргэний эрх зүйн харилцаанд үүргийн гүйцэтгэлийг хангах нэг арга болох анзын нэг хэлбэр торгууль, нөгөөх нь алданги байдаг. Үз. Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.4 ба 232.5 дахь хэсэг.

- тухайн гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай хүн болон хуулийн этгээдэд торгох ял оногдуулахаар Эрүүгийн хуулийн тусгай ангид /зүйлчлэн/ заасан бол торгох ялыг оногдуулж болно;

- торгох ялыг гагцхүү шүүх, шүүх хуралдаан явуулж, шийтгэх тогтоол гаргах арга замаар /хэмжээ, хугацаа зэргийг тусгаж/ оногдуулна;

- торгуулийн тогтоосон нэгжийн хэмжээ буюу торгох ялын итгэлцүүрийг ашиглах байдлаар ялын тооцоолол гаргаж оногдуулна;

- биелэлт нь төрд мөнгөн төлөөс төлөх байдлаар хангагдах учир торгуулийн мөнгийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр тогтоож гаргуулж, зохих дансанд хийлгэх байдлаар хэрэгжинэ.

Манай улсын эрүүгийн эрх зүйгээр эрүүгийн ялыг түүний үйлчлэлийн мөн чанар, эдлүүлэх арга хэлбэрийн онцлогийг харгалзан “үндсэн ял, үндсэн болон нэмэгдэл ял, зөвхөн нэмэгдэл ял” гэж тус тус ангилдаг¹.

Ийнхүү “ялыг тодорхой тогтолцоонд ангилах нь шүүх гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь нотлогдсон шүүгдэгчийн үйлдсэн хэргийн хор аюул, түүний хувийн байдал, ял хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлуудыг харгалзан ялыг оновчтой сонгон оногдуулахад чухал ач холбогдолтой” юм².

Одоогийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн зохицуулалтаас үзвэл торгох нь “үндсэн ялд” хамаарч байна. **Үндсэн ял** гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд уг ялыг дангаар нь оногдуулна гэсэн үг. Мөн уг ял дээр нэмэгдэл ял /эрх хасах/ хэрэглэж болохыг ойлгоно³.

Торгох нь манай түүхэн уламжлалт ял бөгөөд дэлхийн улс орнуудын жишигт ч байдаг. Цээрлүүлэх гол агуулга нь өмчлөх эрхийг нь хязгаарласан материаллаг шинжтэй төрийн албадлага юм. Торгох ял нь нийгмээс тусгаарладаггүйгээрээ ялын тогтолцооны хөнгөн төрөлд багтдаг⁴.

Торгох ялын үндсэн зорилго нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих мэтийн хүнд ялыг хэрэглэхгүйгээр эрүүгийн хариуцлагын гарцаагүй байх зарчмыг хэрэгжүүлэх, нөгөө талаас гэмт этгээдэд материалын хохирол учруулж цээрлүүлэн хашраахад орших⁵ буюу ... гэмт замаар алдагдалтай амьдрах уу, аль эсхүл хууль

¹ Г.Совд. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002., 62 дахь тал.

² С.Жанцан. Дурдсан бүтээл. Боть-II., УБ., 2014., 142 дахь тал.

³ 1986 оны Эрүүгийн хуулиар торгох ялыг үндсэн ялаас гадна нэмэгдэл ялаар хэрэглэж байсан юм. 1993 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлтөөр дан ганц үндсэн ял болгожээ. Үз. 20 дугаар зүйлийн 2. Ардын эрх /сонин/. 1993.06.26., МУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011., 634-635 дахь тал.

⁴ С.Жанцан. Эрүүгийн хариуцлага. УБ., 2006., 10 дахь тал.

⁵ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн цааз /хууль/-ыг өөрчлөх үзэл баримтлал. Монголын төр, эрх зүй. УБ., 1995., №1., 9 дэх тал.

ёсны замаар аж төрөх үү гэдгийг эргэцүүлэн бодоход энэ ял гэм буруутай этгээдэд тодорхой нөлөө үзүүлнэ¹.

Торгох ялын ойлголт, хүснэгтээр:

Төрөл	Хэлбэр	Хэмжээ	Дэглэм	Тогтолцоо
Торгох ял	Биечлэн бус	*- нэгж, 1 нэгж - 1000 төгрөг *- 451-40000 нэгж	Төрд тушаах	Үндсэн ял
Торгох нь торгуулийн мөнгөн нэгжээр хэмжигдэх эдийн засгийн арга хэрэглүүр ашиглаж байгаа эрх зүйн хориглолт учир материаллаг шинжтэй ял бөгөөд ялтны эд хөрөнгийн эрх ашгийг хөндөхөөс өөр хуулийн хязгаарлалт тогтоохгүй.				
Дүйцүүлэх итгэлцүүр нь хуульд заасан торгуулийн нэгж. Торгох ялыг хэсэгчлэн төлүүлэхээр шүүх тогтоож болно. Хэрэв тогтоосон хугацаанд торгох ялыг төлөөгүй тохиолдолд хорих ялаар солих хууль зүйн үр дагавар үүснэ.				
Тайлбар, санал: Гэмт хэрэг үйлдсэн “хүнд” гэж хууль тогтоогч субъектийг заасан атал Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт “хуулийн этгээдэд” уг ялыг оногдуулахаар мөн заажээ. Иймд хууль нь эрх зүйн ном зохиол биш учраас түүнийг хэт хатуугаар муйхарлан эс ойлгож хууль хэрэглээний нэгдмэл ойлголтын зөрүү үүсгэхгүй байх, эсхүл “хуулийн этгээд” гэж нэмэх нь зүйтэй.				

Бусад ялын төрлөөс нийгмээс тусгаарлахгүй шинжээрээ торгох нь хөнгөн ялд тооцогддог, зөвхөн нэг удаагийн үйлчлэлтэй, эдийн засгийн буюу эд материалын эрх, ашиг сонирхолд халдахаас бус ялтны бусад эрхийг хязгаарлахгүй, хөрөнгө чинээ зэргээр хүнийг ялгаварлал тогтоох хандлага үүсгэх эрсдэлтэй, улсын төсөв бүрдүүлэх чиг үүргийг давхар тээж явдаг, зайлшгүйгээр дүйцүүлэх итгэлцүүрийн хөшүүрэг ашиглаж хэмжээг нь тогтоодог зэрэг онцлогтой.

Торгох ялыг эд хөрөнгө хураах ял буюу албадлагын арга хэмжээнээс ялган авч үзэх нь чухал юм. Торгох ба эд хөрөнгө хураахын аль аль нь материаллаг буюу эд хөрөнгийн шинжтэй боловч харилцан адилгүй агуулгатай.

Үүнд: тухайлбал, торгох ялыг дан ганц нэгж буюу төгрөг /мөнгө/ -өөр тооцдог бол эд хөрөнгө хураах үед шүүгдэгчээс мөнгө, ба бусад эд хөрөнгийг албадан гаргуулж авдаг. Торгох нь үндсэн ялын төрөлд хамаарч байхад эд хөрөнгө хураах явдлыг албадлагын арга хэмжээнд тооцдог. Торгуулийн хэмжээг нэгжээр тооцож хуульд шууд тогтоон заасан бол эд хөрөнгө хураахын хувьд бүгдийг буюу эсхүл заримыг нь гэсэн сонголт байдаг. Торгуулиас зайсхийх буюу төлөөгүй тохиолдолд хорих ялаар солих журамтай бол эд хөрөнгө хураахад хохирол нөхөн төлүүлэх гэх зэрэг зорилгоор хийгдэх ажиллагаанд хамаарна.

¹ С.Нарангэрэл. Дурдсан бүтээл. УБ., 1999., 277 дахь тал.

Шүүхийн практик. “Т” нь нэгэн сүлжээ дэлгүүрт менежерээр ажиллаж байхдаа 16 нэр төрлийн 7.891.000 төгрөгийн бараа завшсан гэмт хэрэгт 11.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэгдсэн ба шүүх уг торгох ялыг 3 жилийн хугацаанд сар тутамд хувь тэнцүүлж хэсэгчлэн төлөх хугацааг тогтоож өгчээ¹.

“Т” нь шүүхээс тогтоосон 3 жилийн хугацаанд 11.000.000 төгрөгийн торгох ялаас 2.000.000 төгрөгийн ялыг төлж, 9.000.000 төгрөгийн торгох ялыг хугацаандаа төлж дуусаагүй учир прокурор “Торгох ялыг хорих ялаар солих тухай” дүгнэлт бичиж шүүхэд шилжүүлжээ.

Шүүх Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлд заасан “... Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг 1 хоногоор тооцож хорих ялаар солино” гэсэн заалтыг үндэслэн ялтан “Т”-гийн төлөөгүй 9.000.000 төгрөгийн торгох ялын 15 нэгжийг хорих ялын 1 хоногоор тооцож 600 хоногийн хорих ялаар сольж, нээлттэй хорих байгууллагад эдлүүлж шийдвэрлэжээ.

“Т” нь “... Ковид-19 цар тахлын нөлөөлөл, хил гаалийн хаалттай байдал, хөл хорионы улмаас ажил төрөл хийх, орлого олох боломжгүй нөхцөл байдалд орсон учир торгуулийн ялыг биелүүлж чадаагүй. Торгох ялаа нэн даруй төлнө. Хорих ялыг буцаан торгох ялаар сольж өгнө үү” гэсэн агуулга бүхий давж заалдах гомдол гаргаснаар ... давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцээд:

- торгох ял нь Эрүүгийн хуульд заасан үндсэн төрлийн ял бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас өөр нөхцөлөөр уг ялыг хойшлуулах болон Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, биелүүлэхгүй байх талаар заагаагүйгээс гадна;

- шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс торгох ялаа биелүүлэх талаар шаардахад “... ажилтай болоод очиж чадахгүй байна, төлнө” гэсэн тайлбарыг “Т” нь өгч байсан зэргийг үндэслэн торгох ялыг хорих ялаар сольсон анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй гэж үзэж, хэвээр үлдээж, түүний гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Шигтгээ. Торгох ялын цээрлэл нь ялтны эд хөрөнгийн эрхийг хязгаарлаж, түүнд таагүй үр дагавар буюу эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр төрийн өмчлөлд мөнгөн төлбөр хийж байгаагаар илэрнэ².

Ихэнх орны Эрүүгийн хуульд хэрэглэж байгаа шинж байдлын хувьдаа нийтлэг буюу түгээмэл хандлагатай, зах зээлийн харилцааны нийгэм, эдийн засгийн хэв шинжид тулгуурлагдсан тул голчлон мөнгөн хэлбэртэй, эдийн засгийн

¹ <https://citycourt.mn/site/index.php?newsid=446>. Үз. Торгох ялыг хорих ялаар сольсон нь хуульд нийцсэн гэж үзсэн байна.

² Эрүүгийн хариуцлага /хамтын бүтээл/. УБ., 2006., 32 дахь тал.

хөшүүргийн үүднээс хүний орлого буюу халаас руу төрийн гар шургалж түрийвчтэй ярьдаг гэх мэтийн өнгөц ойлгож болох үндсэн шинжүүдтэй ял нь торгох юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс төгрөгөөр /мөнгөн/ ял оногдуулахыг торгох ял гэж ойлгож болно. Харин одоогийн хуульд заасан шиг энэ нь “төлбөр” биш ээ. Торгох ялыг хэрвээ “төлбөр” гэж үзэх юм бол төрөөс үйлчилгээ авч байгаа утга болох бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөөс болгож хураамж өгч буйтай ижил. Цаашид мөнгөн хэлбэр нь мал, эд зүйл зэрэг бус, төгрөгөөрөө байх нь илүү зохимжтой байна.

Зарим эрдэмтэд “... торгуулийн ялыг “мөнгөн төлбөр” гэж заасан нь үүргийн гүйцэтгэлтэй холбоотой төлбөр мэтээр ойлгогдох утгыг буй болгож байгаа тул зөв томъёологдоогүй” гэж үзжээ¹.

¹ С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж /нэгэн сэдэвт бүтээл/.УБ., 2019., 254 дэх тал.